



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/211

Мандалговь

Сургалтын байгууллагын  
удирдах ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам"-ын 2.2.3, 3.8, 2019 оны А/854 дүгээр тушаалаар батлагдсан "Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, удирдах албан тушаал эрхэлж байгаа багшид мэргэжлийн зэрэг олгох, хасах, мэргэжлийн зэргийг хэвээр хадгалах журам"-ын 2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын арга зүйн зөвлөлийн 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлын санал дүгнэлтийг үндэслэн "Тэргүүлэх багш", "Заах аргач багш" мэргэжлийн зэрэг шинээр олгох сургалтын байгууллагын удирдлагуудын нэрсийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн тооцож олгохыг сургалтын байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Боловсрол, соёл, урлагийн газар (А.Мөнхтуяа)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48201633

Аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр  
сарын 09 -ний өдрийн 411 дугаар  
захирамжийн хавсралт

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ШИНЭЭР ОЛГОХ  
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУДЫН НЭРС

№	Удирдлагуудын нэрс	Байгууллага, албан тушаалын нэр	Үнэлгээ
<b>Нэг. "Тэргүүлэх багш" мэргэжлийн зэрэг</b>			
1	Г.Мөнхтуяа	Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч	97.6
2	М.Туул	Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгч	95.2
3	Л.Дэлгэрмаа	Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн эрхлэгч	95.2
4	Л.Буянтогтох	Эрдэнэдалай сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал	95.2
5	Н.Долгоржав	Луус сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал	91.6
6	С.Алимаа	Сайнцагаан сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч	97.6
<b>Хоёр. "Заах аргач багш" мэргэжлийн зэрэг</b>			
1	Д.Мөнхтогтох	Дэрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал	95.5
2	Б.Цэцэгжаргал	Баянжаргалан сумын цэцэрлэгийн эрхлэгч	95.2
3	А.Алтанчимэг	Говь-Угтаал сумын цэцэрлэгийн эрхлэгч	94.1
4	Д.Сарантуяа	Цагаандэлгэр сумын цэцэрлэгийн эрхлэгч	94.1
5	Ц.Наранбаатар	Өлзийт сумын цэцэрлэгийн эрхлэгч	92.9
6	Н.Дэлгэрсайхан	Өндөршил сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал	87.7
7	Г.Мягмарсүрэн	Сайнцагаан сумын "Говийн ирээдүй" цогцолбор сургуулийн захирал	83.7